

• **ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТАСРАЛТГҮЙ СУРГАЛТ**

1.2022.1.18-ны өдөр “Оношийн хэлбэржилт, нас баралт,түүнийг бүртгэх, мэдээлэх нь” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Удирдсан багш: АШУҮИС, Эмгэг судлал шүүх эмнэлгийн тэнхимийн эрхлэгч, эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, эмгэг судлалын зөвлөх багийн ахлагч Э.Баярмаа.


Сургалтын зорилго: Эмнэлгийн мэргэжилтний эмнэл зүйн ур чадварыг сайжруулах

Сургалтын хэлбэр: цахим, лекц

Сургалтын хугацаа: 3 цаг

Сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо: 50 /эмч -24, резидент-26/

Сургалтын зардал: 400,000 төгрөг /Байгууллагын санхүүжилтээр/



2. 2022.02.18-ны өдөр “Байгууллагын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Сургалтын зорилго: Удирдах албан хаагчдын манлайллын чадварыг нэмэгдүүлэх, удирдлагын баг, тасаг нэгжийн удирдлагын чадавхийг нэмэгдүүлэх

Удирдсан багш/байгууллага: АШУҮИС-ийн НЭМХ, НЭМС, Эрүүл мэндийн бодлого, менежментийн судалгааны төв.

Сургалтын хэлбэр: танхим, дадлага /АӨСҮТ-ийн хурлын танхимд/

Сургалтын хугацаа: 1 өдөр

Сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо: 30

/удирдлагын баг-12, тасаг нэгжийн удирдлага-18/

Сургалтын зардал: 1,424,000 төгрөг /Байгууллагын санхүүжилтээр/



3. 2022.03.04-ны өдөр хамтарч “Сэтгэцийн эрүүл мэнд ба стресс тайлах менежмент” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Сургалтын зорилго: Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд стресс менежментийн чадварт суралцах.

Удирдсан багш: Сэтгэл судлалын магистр, эмч Б.Ариунцацралт

Сургалтын хэлбэр: танхим, дадлага /АӨСҮТ-ийн хурлын танхимд/

Сургалтын хугацаа: 2 цаг

Сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо: 56. /их эмч 34, сувилагч 20, бусад ажилтан 2/.

Сургалтын зардал: үнэ төлбөргүй



4. 2022.04.07.08-ны өдөр “Арьсны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж, хэсэг газрын эмчилгээний онцлог” сэдэвт 1 кр багц цагийн сургалтыг Сувилахуйн алба, Сургалтын алба хамтран цар тахлын дараа анх удаа Улсын хэмжээнд зохион байгуулагдсан, 18 аймгийн арьсны сувилахуйн мэргэжилтэй сувилагч нар хамрагдсан, багц цагийн баталгаажилтыг цахимаар хийсэн зэрэг шинэлэг талтай сургалт зохион байгуулагдав.

Сургалтын зорилго: Арьсны чиглэлээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлдэг сувилагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, дадлыг нэмгдүүлэх.

Удирдсан багш: мэргэжлийн, боловсролын зэрэгтэй 3 их эмч, 8 сувилагч удирдан явуулсан

Сургалтын хэлбэр: танхим, лекц, дадлага /АӨСҮТ-ийн хурлын танхим, хэвтэн эмчлүүлэх тасагт/

Сургалтын хугацаа: 2 өдөр

Сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо: Төвийн 32 сувилагч, тусгай мэргэжилтэн, нийслэл, орон нутаг, хувийн хэвшлийн байгууллагын 38 сувилагч хамрагдсан. Нийт 70 оролцогч.

Сургалтын зардал: 450,000 төгрөг /байгууллагын төсөв/



5. 2022.5.09- 2022.05.25-ны өдрүүдэд 24 цагийн англи хэлний 1 кр сургалт зохион байгууллаа.

Сургалтын алба АШУҮИС-ийн гадаад хэлний тэнхимтэй хамтран зохион байгууллаа.

Сургалтын зорилго: Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн англи хэлний түвшинг сайжруулах.

Сургалтын агуулга: Introduction to medical terminology, Doctor and patient conversation, Abstract writing

Удирдсан байгууллага/алба: АШУҮИС, Биоанагаахын сургууль, гадаад хэлний тэнхимийн багш нар

Сургалтын хэлбэр: танхим, дадлага /АӨСҮТ-ийн хурлын танхимд/

Сургалтын хугацаа: 24 цаг

Сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо: 8

Сургалтын зардал: АУШҮИС-АӨСҮТ хамтын ажиллагааны гэрээний дагуу үнэ төлбөргүй.

6. 2022.5.30 - 2022.06.06-ны өдрүүдэд судалгааны арга зүйн 1 кр сургалт зохион байгууллаа.

Сургалтын зорилго: Нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааны ажлын тоо, чанарыг нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээний ажил, судалгаа хийх мэдлэг чадвар төлөвшүүлэх.

Сургалтын агуулга: Эмнэлзүйн туршилт судалгаа, түүний аргачлал, Шинэ эмийн эмнэлзүйн судалгаа, Ретроспектив судалгаа, Эмнэлгийн чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийх судалгаа, Эмнэлгийн чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийх судалгаа, Чанарын судалгааны аргууд, мэдээлэл цуглуулах ба мэдээлэл боловсруулах арга Dermatology journal club.

Удирдсан багш: АШУҮИС, Эрдмийн сургууль, Эрүүл мэндийн судалгааны тэнхимийн багш нар.

Сургалтын хэлбэр: танхим, лекц, дадлага /АӨСҮТ-ийн хурлын танхимд/

Сургалтын хугацаа: 24 цаг

Сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо: давхардсан тоогоор 62 /эмч нар 30, резидент эмч 32/

Сургалтын зардал: АУШҮИС-АӨСҮТ хамтын ажиллагааны гэрээний дагуу үнэ төлбөргүй.



7. 2022.06.15-нд "Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлье" чанар сайжруулах аяны хүрээнд "Байгууллагын шинэ соёл" сэдэвт сургалтыг I тасгийн зохион байгууллаа.

Удирдсан багш: Хүний их эмч, эрх зүйч Б.Одгэрэл

Сургалтын хэлбэр: танхим, лекц /АӨСҮТ-ийн хурлын танхимд/

Сургалтын хугацаа: 2 цаг

Сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо: 57/44 ажилтан, 13 резидент эмч/

Сургалтын зардал: 100,000 төгрөг /Байгууллагын санхүүжилтээр/



8. 2022.06.10- 06,11-ны өдрүүдэд Эрүүл мэндийн чанарын холбоо ТББ-тай хамтран “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал” сэдэвт чанарын сургалт зохион байгууллаа.

Сургалтын зорилго: эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах

Удирдсан багш/байгууллага: Эрүүл мэндийн чанарын холбоо ТББ

Сургалтын хэлбэр: танхим, дадлага /АӨСҮТ-ийн хурлын танхимд/

Сургалтын хугацаа: 2 өдөр



Сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо: чанарын багийн ахлагч 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн

Сургалтын зардал: 600,000 төгрөг /Байгууллагын санхүүжилтээр/



2022 оны I улиралд 2022-2026 оны байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хүний нөөцийн албатай хамтран боловсруулж, II зорилтын хүрээнд тасралтгүй суралцагч байгууллага байж, хүний нөөцийг хөгжүүлэх, сургалт хөгжлийг

дэмжих 5 үйл ажиллагаа төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шаттайгаар хангаж ажиллах хүрээнд 2022 оны байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусган, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Төгсөлтийн дараах сургалт

Эрүүл мэндийн бодлого удирдлага чиглэлээр /АШУҮИС, НЭМС, ЭМБУ тэнхим, 6 сар/ 1 удирдах ажилтан

Арьс судлалын мэргэжил дээшлүүлэх сургалтанд / АШУҮИС, МДИ-ийн 3 сар / 2 их эмч

Арьсны сувилахуйн нарийн мэргэжлийн чиглэлээр / ЭМХТ, АӨСҮТ 3 сар / 5 сувилагч

Мэс заслын сувилахуйн чиглэлээр / ЭМХТ, АӨСҮТ, 3 сар / 1 сувилагч

Эмнэл зүйн дархлаа судлал чиглэлээр /ЭМХТ, УНТЭ, 3 сар/ 1 сувилагч суралцаж байна.

• ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА, НИЙГЭМЛЭГЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС 32 УДААГИЙН СУРГАЛТАНД АӨСҮТ-ИЙН ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД ХАМРАГДСАН. ҮҮНД:

1. 2022.1.6-ны өдөр “Томуу томуу төст өвчний үед үзүүлэх тусламж, үйлчилгээ” сэдэвт сургалтанд хамрагдлаа.

Сургалт зохион байгуулагч: ЭМХТ

Сургалтын хэлбэр: цахим

Сургалтанд оролцогч: Халдвар судлалын албаны дарга Г.Долгорсүрэн.


2. 2022.01.26-ны “SARS-COV-2 вирусийн омикрон хувилбарын эсрэг хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах”

Сургалт зохион байгуулагч: ЭМЯ

Сургалтын хэлбэр: цахим

Сургалтанд оролцогч: Их эмч Б.Номин, Б.Ганбаяр, С.Билгүүнцоож, Б.Баярмаа, М.Отгонбаяр нарын эмч нар тасаг бүрээс ажил үүргийн зохицуулалт хийн сургалтанд оролцуулж, оролцогчид тасгийн бусад эмч нарт мэдээлэл хүргэж ажиллав.

3.2022.01.28-нд ЭМЯ, ЭХЭМҮТ, СЭМҮТ-ээс зохион байгуулсан “Хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэхэд түгээмэл тохиолдож байгаа алдаа” сургалтанд тасгийн эрхлэгч, хэвтэн эмчлүүлэх тасгийн эмч нар цахимаар хамрагдсан.




4. 2022.02.10-нд ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газраас зохион явуулсан “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах” сэдэвт хэлэлцүүлэгт эмнэл зүйн эм зүйч С.Пүрэвсүрэн оролцсон.



АӨСҮТ-н Эм зүйн алба нь ЭЭХХЗГ-аас зохион явуулсан “Эмийн аюулгүй байдлын идэвхтэй тандалтын сарын аян”-д оролцож улсын болон хувийн хэвшлийн нийт 70 гаруй эмнэлгүүдээс 3-р байрт шалгарч үнэлүүлсэн.




5. 2022.02.25-нд АШҮУИС болон “Фройка ХХК”-аас зохион байгуулсан “Хайрст үлдийн шинэ эмчилгээний удирдамж болон биологийн бэлдмэлийн эмнэлзүйн тохиолдол” сургалтанд “Секукуномаб биологийн бэлдмэлийг хэрэглэх үеийн өвчтөний хяналт” сэдэвт лекцийг зөвлөх эмч Г.Цогзол удирдан явуулсан, сургалтанд нийт эмч нар цахимаар хамрагдсан.




6. 2022. 3 сард “Ажлын эмх цэгц, минимал амьдралын хэв маяг, цаг төлөвлөлт хувийн зохион байгуудалт” цуврал цахим сургалтанд захиргааны тасгийн хамт олон хамрагдсан.


7. Дижитал Медик ХХК, ЭМХТ-өөс зохион байгуулсан “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан программ хангамж” сургалт IT инженер Ганзориг, сургалтын арга зүйч Б.Номин нар хамрагдсан.



8. 2022.03.02-нд Баянгол мед-ээс зохион байгуулсан коагулограммын аппарат ашигдах зааврын сургалтанд лабораторийн тасгийн ихх эмч А.Дулмаа хамрагдаж авсан олж авсан мэдлэгээ тасгийн хамт олондоо 03.03-нд танилцуулсан.




9.2022.01.28,2022.02.18,2022.03.26 -өдрүүдэд Поликлиникийн тасгийн их эмч Д.Мөнгөнтүлхүүр МХСН-с зохион байгуулж буй virtual CASE REPORT vCARE1, vCARE2, vCARE3 цахим сургалтанд тус тус хамрагдсан.




10.2022.3.24-нд ШУГТЭ "Гематологийн шинжилгээний 27 дахь биохимийн шинжилгээний 21 дэх, цусны бүлэг тохиргооны 16 дахь удаагийн удаагийн чанарын гадаад үнэлгээний ур чадварын үнэлгээ ба стандарчлал" сэдэвт тайлан семинарт лабораторийн эмч А.Дулмаа хамрагдсан.

11. 2022.03.25-нд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, иргээдийн хэрэглээний боловсролын төвөөс зохион байгуулсан “Иргэн бүрт эрүүл мэнд” аяны хүрээний Эрүүл мэндийн сургалтанд. Төвийн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.


12.2022.04.11-нд ЭМХТ-өөс зохион байгуулсан “Халдварт өвчний эрт илрүүлэг” сэдэвт сургалтанд лабораторийн тасгийн Ж.Энхжаргал, А.Дулмаа эмч нар цахимаар хамрагдсан.



13. 2022.04.14-нд “Пост-ковид менежмент” сэдэвт сургалтыг Сонгодог эмнэлгийн зүрх судас, ангиографийн эмч Ц.Намхайдорж Гедеон рихтер ХХК-аас АӨСҮТ-ийн хурлын танхимд явуулсан. Сургалтан 32 эмч хамрагдсан.



14. 2022.04.25-нд ЭМЯ-аас зохион байгуулсан "Эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын үйлчилгээнд тулгамдсан асуудал" сэдэвт сургалтанд хүүхдийн тасгийн Б.Золбаяр эмч хамрагдсан.



15. 2022.05.02-нд ЭМЯ-аас зохион байгуулсан “Цалингийн гүйлгээг цахимжуулах” сургалтанд санхүүгийн албаны нягтлан бодогч Б.Мядаг Б.Ууганчимэг нар хамрагдсан.


16. 2022.05.09-нд Төрийн өмчийн бодлого зрхицуулалтын газраас зохион байгуулсан Улаанбаатар хот дахь төрийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга, үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан, нярав нарт зориулсан сургалтанд аж ахуйн албаны дарга Т.Мөнхцацрал, нягтлан боодогч А.Сэлэнгэ нар хамрагдсан.



17. 2022.05.12-ны өдөр Монгол Улсын их хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн санаачилгаар зохион байгуулсан “СУВИЛАГЧИД ЭЭЛТЭЙ МОНГОЛ” 2022 сувилахуйн чуулга уулзалтанд хүүхдийн тасгийн ахлах сувилагч Х. Эрдэнэтуяа, I-р тасгийн ахлах сувилагч Б. Жавхлант, Эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасгийн сувилагч Т. Оюунбилэг, II-р тасгийн сувилагч У. Хажидмаа нар оролцсон.



18. 2022.05.26-ны өдөр Төрийн албаны зөвлөл, Монголын оюун ухааны академи хамтран зохион байгуулсан “Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүй” сургалтанд 10 ажилтан цахимаар харагдсан.



19. 2022.05.27-ны өдөр “Эмгэг судлалын лабораторийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтанд лаборант Х.Гэрэлсүрэн хамрагдсан.


20. 2022.05.29-нд Арьс судлаачдын монголын нийгэмлэгээс зохион байгуулсан “Арьс судлаачдын монголын нийгэмлэгийн хаврын эрдэм шинжилгээний хурал VI” эрдэм шинжилгээний хуралд АӨСҮТ-ийн 11 эмч (Б.Батцэцэг, Б.Номин, С.Солонго, Ч.Эрдэнэчимэг, М.Мөнгөнтүлхүүр, У.Саруул, О.Урангоо, Х.Энхжин, Б.Энхсайхан, О.Билгүүнцөөж, Ж.Энхжаргал) хамрагдсан.



21. 2022.06.17-ны өдөр Монголын харшил судлалын нийгэмлэгийн 18-р чуулганд их эмч Б.Энхсайхан хамрагдсан.



22. 2022.06.27-ны өдөр Шилэн дансны системийн шинэчлэлийн сургалтанд санхүүгийн албаны дарга Б.Мядаг цахимаар оролцсон.



23. 2022.06.28-ны өдөр АУШУУИС-ийн Монгол-Японы эмнэлэг, ХӨСҮТ хамтран зохион байгуулсан “Эмнэлгийн халдварын сэргийлэлт хяналт-Олон улсын жишиг тогтолцоо” сэдэвт сургалтанд халдвар судлаач Г.Долгорсүрэн, чанарын албаны дарга Б.Баярмаа нар хамрагдсан.



24. 2022.06.29-ны өдөр Ковид-19 оношлуур, хэрэгслийн орлого, зарлагын мэдээллийг www.burtgel.mohs.mn сайтад оруулах зааварчилгаа сургалтанд эм зүйн албаны дарга Э.Мөнхгэрэл, лабораторийн тасгийн эрхлэгч Ж.Энхжаргал, лаборант У.Буманзаяа нар цахимаар хамрагдсан.

25. 2022.06.30-ны өдөр Цусны донорын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт ЭГЗНСТ-ийн их эмч Б.Амаржаргал цахимаар оролцсон.

- Төлөвлөгөөт бус 32 сургалт зохион байгуулагдсан. Үүнээс 48 цагаас дээш хугацаатай сургалтууд нь:


26. 2022.03.02, 09, 16, 23-ны өдрүүдэд “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчдийн ур чадварыг бэхжүүлэх” сэдэвт сургалтанд оролцсон.

Сургалтын агуулга: Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх шинжээчдийн ур чадварыг нэмэгдүүлэх, магадлан шинжлэх үйл ажиллагааны дүрэм, журмыг мөрдөн ажиллах, шинжээчийн хараат бус байдал зэрэг сэдвүүдийн хүрээнд.

Сургалт зохион байгуулагч: ЭМХТ

Хугацаа: 4 өдөр

Оролцогч: Хэвтэн эмчлүүлэх I тасгийн эрхлэгч эмч А.Байгалмаа, поликлиникийн тасгийн эрхлэгч эмч Г.Цогзол нар



27. 2022.04.19-2022.04.20-ны өдөр "Эрүүл мэндийн байгууллагын цахим ур ур чадварыг хөгжүүлэх нь" сэдэвт сургалтан оролцсон.

Сургалт зохион байгуулагч: ЭМЯ

Хугацаа: 2 өдөр

Оролцогч: Гүйцэтгэх захирал Ц.Уранчимэг, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Баярмаа, эмчилгээ эрхэлсэн дэд захирал Б.Батцэцэг, мэдээлэл технологийн албаны дарга Б.Ганзориг нар.



28. 2022.04.18-20-ны өдрүүдэд "Байгууллагын архивын баримтын цахимжуулалт, тоо бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт" сэдэвт сургалтанд оролцсон.

Зохион байгуулагч: ЭМЯ

Хугацаа: 3 өдөр

Сургалтын агуулга: Байгууллагын архивын баримтын цахимжуулалт, тоо бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалтаар мэргэшүүлэх сургалт

Оролцогч: Архивын ажилтан Т.Мөнхцацрал.



29. 2022.05.10, 11-ны өдрүүдэд “Хавдрын үеийн сувилгахуйн тусламж, үйлчилгээ” үндэсний хэмжээний сургалтанд оролцсон.

Зохион байгуулагч: ЭМЯ, ХСҮТ

Хугацаа: 2 өдөр

Сургалтын агуулга: “Элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах үеийн асаргаа сувилгаа”, “Колостомын үеийн сувилгахуй”, “Трахестомын үеийн сувилгахуй”, “Хими эмчилгээний үеийн портын сувилгаа”, “Туяа эмчилгээний үеийн арьсны сувилгаа” зэрэг 5 өртөөгөөр сувилагчийн гардан ажилбарын дадлага сургалтыг зохион байгуулж “Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар-аюулгүй байдалд тулгамдаж буй асуудлууд” сэдвээр бүлгийн хэлэлцүүлгүүдийг хийлээ.

Орорлцогч: Сувилахуйн албаны дарга Ө. Ариунаа, хүүхдийн тасгийн ахлах сувилагч Х. Эрдэнэтуяа, I тасгийн ахлах сувилагч Б. Жавхлант нар.



30. 2022.05.18 - 2022.05.21 “Корона вируст халдвар/ковид-19-халдварын дараах сэргээн засах тусламж, үйлчилгээ болон Олон улсын жишигт нийцсэн орчин үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чиг хандлага” сэдэвт багц цаг олгох сургалтанд оролцсон.

Зохион байгуулагч: ЭМЯ

Хугацаа: 2 өдөр

Сургалтын агуулга: Эрчимт эмчилгээний дараах хам шинж, цочмог үеийн хүндрэлүүд, ковид-19 халдварын дараах байдлын сэргээн засах эмчилгээ хийх менежмент.

Оролцогч: ЭГЗНСТасгийн их эмч И.Мөнхзаяа.




31. 2022.05.19-20-ны өдрүүдэд ЭМЯ болон ХӨСҮТ-ийн хамтарсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент” сэдэвт сургалтанд оролцсон.

Зохион байгуулагч: ЭМЯ, ХӨСҮТ

Хугацаа: 2 өдөр

Сургалтын агуулга: ЭМБХХ-ыг хадгалах, эмнэлгээс гадагш тээвэрлэлт, анхаарах асуудлууд, түүнийг хэрхэн сайжруулах төлөвлөгөө, арга замууд, вакцин ба био бэлдмэл халдваргүйжүүлэх уусмал, ЭМБ-ын ХСХ-ын хог хаягдлын мэдээ, дүн шинжилгээ

Оролцогч: Халдвар судлаач Г.Долгорсүрэн.



32. 2022.06.10,11,12- ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Цахим орчинд эрсдэлийн үеийн мэдээллийг үнэлэх, контент бэлтгэх, хөгжүүлэх, түгээх чадварыг нэмэгдүүлэх” онол, практикийн хослосон сургалтанд оролцсон.

Зохион байгуулагч: ЭМЯ

Хугацаа:3 өдөр

Сургалтын агуулга: Сургалтанд харилцааны ур чадвар, камер ашиглах, мэргэжлийн зураг авах арга техник, багаар ажиллах, хэвлэлийн тойм, мэдээлэл түгээх арга аргачлал гэх зэрэг сэдвүүдийн хүрээнд

Орорлцогч: НЭМА Х.Хэрлэн



33. 2022.06. 21,22,23-ны өдрүүдэд сувилахуйн “Эмнэл зүйн сургагч багш”-ийн сургалтанд амжилттай хамрагдсан.

Зохион байгуулагч: ЭМХТ

Хугацаа: 3 өдөр


Оролцогч:Сувилагч А.Дэжидмаа

33. Эмнэл зүй, эмгэг судлалын онош хэлбэржүүлэн тавих, оношийн зөрүү ба тохироог үнэлэх асуудал ДЭМБ-ийн зөвлөмжийн дагуу шинэчлэгдсэн тул тус стандартыг танилцуулах, эмнэл зүйн эмч нарт онош хэлбэржүүлэн тавих, өвчний олон улсын ангиллын дагуу кодлох талаарх сургалтыг Эмгэг Судлалын Үндэсний Төвөөс АӨСҮТ-д танхимын хэлбэрээр амжилттай зохион байгуулагдлаа.



2. Өндөр хөгжилтэй оронд суралцан, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд дэмжлэгт удирдлагаар хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд:

Их эмч Т.Баярмаа, У.Саруул, М.Отгонбаяр нарын 3 эмч Монголын Эрүүл Мэндийн Нийгэмлэгүүдийн Нэгдсэн Холбоо, ОХУ-ын РУДН-ийн мэргэжил дээшлүүлэх институт, иммунологи харшил судлалын тэнхимтэй хамтарч зохион байгуулсан Харшил иммунологийн төрөлжсөн мэргэшлийн цахим, танхим хосолсон 3 сарын хугацаатай сургалтанд 2021 оны 12 сараас эхлэн суралцсан. Ийнхүү төрөлжсөн нарийн мэргэшилтэй эмч нарын тоо 10 хувиар нэмэгдүүлсэн.



- Seoul National University Hospital /Сөүлийн Үндэсний Их Сургуулийн Эмнэлэгт 1 сарын хугацаатай ажлын байрны сургалтанд эмчилгээний гоо засал нөхөн сэргээх тасгийн их эмч Б.Амаржаргал 2022.08.15-2022.09.14-ний хооронд 1 сарын хугацаатай суралцах урилга ирүүлсэн ба Сөүлийн Үндэсний Их Сургуулийн төлөөлөгчтэй хамтран холбогдох бичиг баримт бүрдүүлэх шатанд явагдаж байна.



- Энэтхэгийн Max Healthcare Institute Limited эмнэлэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургалтанд хамруулах хамтран ажиллах гэрээ 2022.06 сард байгуулав.